



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 14


Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

VI. ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хараат компаниуд болон хамтран ажиллах гэрээний хүрээнд үйл ажиллагаа явуулж буй компаниудын талаар болон ажилтнуудтай байгуулсан контрактыг дүгнэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016-2019 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт хийсэн Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хамтарсан санхүүгийн хяналт, шалгалтын ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрдмин” ХХК, “Шим технолоджи” ХХК, “Эрдэнэт ойл” ХХК, “Медипас” ХХК, “Ачит Ихт” ХХК, “Зэс эрдэнийн хувь” ХХК, “Морьт эксплорейшн” ХХК, “Монголросцветмет” ХХК(хуучин нэрээр)-ийн талаар авах арга хэмжээний тухай санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ажлуулан хэрэгжилтийг хангах, үйлдвэрийн зарим эрх бүхий албан тушаалтнуудтай байгуулсан контрактыг дүгнэж, дуусгавар болгох, шүүхийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, шаардлагатай бол хууль, журмын хүрээнд эвлэрэн тухайн хэрэг бүрт адилгүй хэлэлцэж, үйлдвэрт ашигтай хэлбэрээр хуульд нийцүүлэн шийдвэрлэхийг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд даалгав.” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



000039